



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/165

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 14 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1.Засгийн газрын болон аймгийн Засаг даргын шийдвэр, хэрэгжилт цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх сурталчилах ажлыг хийсэн "Монгол Ньюс" ХХК, Зариг.мн сайтын хэвлэлийн зардалд шаардагдах 2,100,000 (хоёр сая нэг зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.
- 2.Хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т үүрэг болгосугай.
- 3.Захирамжийн хяналт, гүйцэтгэл, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР